Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 06-р сарын 25-ны
өдрийн 008 тоот тогтоолын хавсралт №01

“ХАТАН СУУДАЛ ИНВЕСТ ББСБ” ХХК

ХАТАН
СУУДАЛ ИНВЕСТ
ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ

ЁС ЗҮЙН КОДЕКС

BOD-200 P

УЛААНБААТАР ХОТ

Баримт бичгийн нэр: Ёс зүйн кодекс	Хариуцах эзэн: ТУЗ Нарийн бичгийн дарга
Хамрах хүрээ: “Хатан Суудал Инвест ББСБ” ХХК-ийн нийт ажилтнууд	Ангилал: Дотоод хэрэгцээнд
Танилцах: Бүх ажилтан	Хуудасны тоо: 7

Баримт бичгийн хяналтын хувилбар

Хувилбар	Сүүлд шинэчлэгдсэн	Шинэчлэлт хийсэн	Тайлбар
1.0	2020.09.01		Анхны хувилбар
2.0	2021.07.20		Шинэчилсэн хувилбар
3.0	2024.03.02		Шинэчилсэн хувилбар
3.1	2024.06.25		Нэмэлт өөрчлөлт

Зөвшөөрөл

Энэхүү журмын анхны хувилбарыг ТУЗ Тогтоолоор батална. Нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг ТУЗ-ийн дарга, Дотоод хяналтын хэлтсийн саналаар хэлэлцэж, ТУЗ Тогтоолоор батална.

Хэвлэгдсэн байдал

Энэхүү журмыг нэг хувиар баталж, компанийн эрх бүхий албан тушаалтан, нийт ажилтан, харилцагч, үйлчлүүлэгчид, бизнесийн үйл ажиллагаанд оролцогч талууд уншиж танилцах боломжтойгоор хэвлэв.

Агуулга

Нэг. Нийтлэг үндэслэл 4
Хоёр. Компанийн үйл ажиллагаа 4
Гурав. Компанид хамаарал бүхий этгээдүүдтэй харилцахад болон 5
тэдгээрийн баримтлах ёс зүйн хэм хэмжээ 5
Дөрөв. Хяналт, хариуцлага 7

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Ёс зүйн кодекс (**"Кодекс"**)-ын зорилго нь "Хатан Суудал ББСБ" ХХК (**"Компани"**), түүний салбарын бизнесийн үйл ажиллагааг хууль ёсны, ёс зүйтэй явуулах, хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, ажилтнууд үйл ажиллагаандаа удирдлага болгон дагаж мөрдөх, өндөр түвшний ёс зүйг төлөвшүүлэхэд оршино.

1.2. Ёс зүйн кодексоор Компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтны үйл ажиллагаандаа баримтлах зарчим, ёс зүйн хэм хэмжээг тогтоож, түүнийг мөрдүүлэх, хэвшүүлэхэд холбогдсон харилцааг зохицуулна.

1.3. Компани Кодексын шинэчлэлт, хэрэгжилт, өөрчлөлтийг Компани, түүний салбарын дүрэмд нийцүүлэн мөрдүүлж, ёс зүй, хууль ёсыг баримтлан, сайн компанийн засаглалыг дэмжиж ажиллана.

Хоёр. Компанийн үйл ажиллагаа

2.1 Компани, түүний салбарын үйл ажиллагааны ёс зүйн хэм хэмжээ нь ил тод, шударга, найдвартай, үнэнч байх зарчимд суурилна.

2.2 Компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтан нь ажил, үүрэг гүйцэтгэхдээ холбогдох хууль, тогтоомж, Кодекс болон дараах ёс зүйн хэм хэмжээ, зарчмыг баримтлан ажиллана.

2.2.1 Үйл ажиллагаандаа хууль тогтоомж, дүрэм, журмыг чандлан мөрдөнө;

2.2.2 Үйл ажиллагаагаа шударга, ил тод, нээлттэй байдлаар явуулна;

2.2.3 хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагч, харилцагч, бэлтгэн нийлүүлэгч, хэрэглэгч, ажилтнууд зэрэг оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэнэ

2.2.4 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг эрхэмлэнэ;

2.2.5 Ажилтан бүрд эрх тэгш, хүндэтгэлтэй хандан аюулгүй байдалд ажиллах орчныг бүрдүүлнэ;

2.2.6 Олон талт оролцоо, багийн ажиллагааг хөгжүүлсэн харилцан итгэлцэл, хүндлэл бүхий хамтын ажиллагааг эрхэмлэнэ;

2.2.7 Компанийн нэр хүнд, өмч хөрөнгийг хамгаална;

2.2.8 Байгууллагын нууц болон үйл ажиллагааныхаа дагуу олж мэдсэн хувь хүний нууцыг холбогдох хуульд заасны дагуу хамгаална.

2.3. ТУЗ-ийн дарга, гишүүний ёс зүйн хэм хэмжээ

2.3.1. Хууль тогтоомж, хувьцаа эзэмшигчдийн хурал, компанийн дүрэм болон ТУЗ-ийн шийдвэрээр тогтоосон эрх, үүргээ Кодекс заасан ёс зүйн зарчимд бүрэн нийцүүлэх;

2.3.2. Байгууллагын соёлыг хөгжүүлэх;

2.3.3. Хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хангах;

2.3.4. Компанийн аливаа шийдвэр, үйл ажиллагаанд хувийн сонирхлоор хандахгүй, албан тушаалын давуу байдал үүсгэхгүй байх;

2.3.5. Бусдад хүндлэлтэй хандах;

2.3.6. Дотоод мэдээллийг хууль бусаар ашиглахгүй, задруулахгүй байх;П

2.3.7. Эрх үүргээ хэрэгжүүлэхдээ хичээл зүтгэл гаргаж ажиллах;

2.3.8. Аливаа асуудалд үндэслэлтэй, шударга хандах;

2.3.9. Өөрийн болон нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээллийг компанийн эрх бүхий албан тушаалтанд гаргаж өгөх;

2.3.10. Сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэж, тухайн асуудлаар санал хураалтад оролцохгүй байх;

2.3.11. Өөрийн болон эрх бүхий албан тушаалтан, ажилтны мэдлэг, чадварыг байнга хөгжүүлэх;

2.3.12. Кодексыг зөрчих үйлдэл, эс үйлдлээс татгалзах, шаардлагатай тохиолдолд бүрэн эрхээсээ татгалзах ёс зүйтэй байх.

2.4. Гүйцэтгэх удирдлагын ёс зүйн хэм хэмжээ

2.4.1. Компанийн дүрэм, журам, гэрээнд заасан эрх үүргээ хэрэгжүүлэхдээ хууль тогтоомжийг баримтлах;

2.4.2. Үйл ажиллагаагаа шударга, ил тод, нээлттэй байдлаар явуулах;

2.4.3. Ажилтны саналыг сонсож, харилцан уялдаа бүхий эргэх холбоотой ажиллах;

2.4.4. Компанийн нэрийн өмнөөс оролцогчидтой харилцахдаа ёс зүйн хэм хэмжээг чанд сахих;

2.4.5. Албан үүргээ гүйцэтгэхдээ хамт олонтойгоо эелдэг, тэгш, хүлээцтэй, хүндэтгэлтэй хандах;
2.4.6. Өөрийн буруутай үйл ажиллагааны хариуцлагыг шударгаар хүлээж, дахин давтахгүй, шаардлагатай тохиолдолд албан тушаалаасаа татгалзах ёс зүйтэй байх;
2.4.7. Кодексыг зөрчсөн аливаа үйлдэлтэй үл эвлэрч, өөрийн болон бусдын алдаа, дутагдлыг илрүүлэн засаж, ажиллахыг эрмэлзэх.

2.5. Ажилтны ёс зүйн хэм хэмжээ
2.5.1. Хууль тогтоомж, компанийн дүрэм, дотоод журмыг чанд баримталж, компанийн нэр хүндийг дээдлэх;
2.5.2. Өөрийн мэдлэг, чадварыг байнга хөгжүүлж, үүрэгт ажлаа мэргэжлийн түвшинд үнэнч шударгаар хариуцлагатай гүйцэтгэж, ажилдаа хүндэтгэлтэй хандах.

2.6. Компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтан ашиг сонирхлын зөрчил, авлигаас сэргийлэх чиглэлээр дараах сонирхлын зөрчилтэй үйлдэл хийхийг хориглоно. Эдгээр хориглосон үйлдэл, үйл ажиллагаа явуулах нь ёс зүйн зөрчилд хамаарна.
2.6.1. Хамаарал бүхий этгээдүүдийн хооронд хийх аливаа гэрээ, хэлцэл;
2.6.2. Хамаарал бүхий этгээдийн оролцсон Засгийн газартай хийх аливаа гэрээ, хэлцэл;
2.6.3. Компани, түүний салбарын ажилтан, харилцан хамаарал бүхий этгээд, эрх бүхий албан тушаалтан шууд болон шууд бус замаар хувийн ашиг сонирхолдоо нийцэх, давуу байдал бий болгох, бусад байгууллага, хуулийн этгээдтэй бие даан өөрийн ашиг сонирхлын үүднээс хийж буй аливаа гэрээ, хэлцэл;
2.6.4. Компани, түүний салбартай харилцаа тогтоохыг хүссэн аливаа этгээдээс хөлс, шан харамж, бэлэг зэрэг өөрт ашигтай саналыг хүлээн авах, эсвэл эдгээр саналыг бусдад тавих;
2.6.5. Компани, түүний салбарын эдийн болон эдийн бус хөрөнгийг хувийн ашиг сонирхолдоо ашиглах;
2.6.6. Албан үүргээ биелүүлэх явцдаа олж мэдсэн Компанийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх аливаа мэдээлэл болон өөрт итгэмжлэн хадгалуулсан болон Компанийн нууцад хамаарах мэдээллийг задруулсан, хувийн ашиг сонирхолдоо ашигласан;
2.6.7. Компанийн ашиг сонирхол, үйл ажиллагаатай холбоотой аливаа ажлыг Компанийн харилцагч, өрсөлдөгч, нийлүүлэгч, хувьцаа эзэмшигчид зориулан гүйцэтгэх;
2.6.8. Компанийн харилцагч, өрсөлдөгч, нийлүүлэгч, хувьцаа эзэмшигчтэй шууд болон шууд бус эдийн засгийн болон санхүүгийн ашиг сонирхолтой байх;
2.6.9. Улс төрийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхгүй байх, хандив тусламж өргөхгүй байх, аливаа нам эвслийг сурталчлахгүй байх, авлига хээл хахуулиас ангид байх;

2.7. Ашиг сонирхлын зөрчлийг зөвхөн санхүүгийн боломж, давуу талыг бий болгож байгаагаар тодорхойлохгүй бөгөөд эрх бүхий албан тушаалтан, ажилтан Компанийн ашиг сонирхол, үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ өөрийн үүргээ ухамсарлаж, ажилдаа хангалттай анхаарал хандуулж, хариуцлагатай байгаа эсэхээр нь дүгнэж болно.

Гурав. Компанид хамаарал бүхий этгээдүүдтэй харилцахад болон тэдгээрийн баримтлах ёс зүйн хэм хэмжээ

3.1 Ажилтнууд болон эрх бүхий албан тушаалтнууд:
3.1.1 Бүх ажилтнууд хүний эрхийг дээдэлж, Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн дагуу Компанид урт хугацаагаар, тогтвортой ажиллах, хөдөлмөрийн харилцаанд үнэнч, хүндэтгэлтэй хандах;
3.1.2 Хүүхдээр хөдөлмөр эрхлүүлэхгүй байх;
3.1.3 Бизнесийн боломж, шинэ санаа, хандлага, багийн болон ганцаарчилсан ололт, амжилтыг дэмжиж, урамшуулах;
3.1.4 Үйл ажиллагааны үр дүнг бууруулж байгаа удирдлагын буюу хэт шаталсан захиргааны бүтэц, хэлбэрээс татгалзах;
3.1.5 Ажилтнуудын ажиллах орчныг сайжруулах, зохих ёсны тав тухтай, эрүүл, аюулгүй байлгах нөхцөлийг хангах;
3.1.6 Ил тод байдлыг зохих хэмжээнд хангах;
3.1.7 Шагнал урамшуулал, нөхөн төлбөр, дэмжлэгийг ажилтан бүрд ялгаваргүйгээр тэгш олгох;

3.1.8 Ажилтнуудыг ажлын байран дахь бэлгийн болон аливаа бусад дарамт, ялгаварлан гадуурхалтад өртөхөөс хамгаалах, эдгээр дарамтыг шалгаж, илрүүлэн, зохих аргаар шийдвэрлэх;

3.1.9 Үйл ажиллагааны чиглэл, онцлогоос хамаарч ажилтныг ганцаар эсвэл багаар ажиллуулах;

3.1.10 Бүх ажилтнуудыг мэргэшил, ур чадвараа дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зохих сургалтад хамруулах, заах, зөвлөх;

3.1.11 Компанийн дотоод болон нууц мэдээллийг ажилтнууд болон эрх бүхий албан тушаалтан задруулсан, хууль бусаар ашигласан тохиолдолд хариуцлага хүлээлгэх;

3.1.12 Компани, түүний салбарын удирдлага болон ажилтнууд байгууллагын хүний нөөц, хөдөлмөрийн харилцаа болон хөдөлмөрийн нөхцөлтэй холбоотой бусад асуудлаар харилцан туслалцаа үзүүлэх, хэлэлцэж шийдвэрлэх, сайн туршлагыг хэрэгжүүлэх нөхцөлөөр хангах;

3.1.13 Ажилтнаас /нэрээ нууцалсан байж болно/ Компанийн удирдлага, үйл ажиллагааг алдаатай, алдагдалтай, хууль бус явуулж байгаа тухай болон эдгээрээс урьдчилан сэргийлсэн мэдэгдлийг бусдад задруулахгүйгээр, удирдлагаас айх айдасгүйгээр гаргаж тавих нөхцөлийг бүрдүүлэх ба энэ тохиолдолд мэдэгдэл үндэслэлтэй эсэхийг шуурхай шалгах арга хэмжээ авах;

3.1.14 Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжид заасны дагуу хөдөлмөрийн харилцааг дуусгавар болгох, уг хууль тогтоомжийг мөрдөж ажиллах;

3.2 Харилцагчид:

3.2.1 Харилцагчийн сэтгэл ханамжтай байдал нь Компани, түүний салбар чухал нөлөөтэй. Компанийн харилцагчтай харилцах харилцааг шударга, найдвартай, боломжит үнэ, чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтаар тодорхойлно.

3.2.2 Харилцагчид санал болгож буй бүтээгдэхүүн ба үйлчилгээ нь тэдний хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

3.2.3 Харилцагчийг өрийн хэт их дарамтад оруулахаас урьдчилан сэргийлж, зээлийн хэмжээг тэдний төлбөрийн чадвартай уялдуулан зөв тооцоолно.

3.2.4 Харилцагчид санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ ханшийг ил тод байлгана.

3.2.5 Харилцагчийн мэдээллийн нууцлалыг чандлан хадгална.

3.2.6 Харилцагчийн санал гомдлыг түргэн шуурхай шийдвэрлэдэг байна.

3.3 Хамтран ажиллагч:

3.3.1 Хамтран ажиллагч нартай удаан хугацааны тогтвортой, найдвартай, үнэнч, шударга, харилцан ашигтай, хүндэтгэлтэй харилцааг бий болгох;

3.3.2 Бизнесийн үйл ажиллагааны явц дахь болон гэрээгээр хүлээсэн үүрэг, хариуцлагаа биелүүлэх;

3.3.3 Олон талын ашигтай гэрээ, хэлцэл байгуулах;

3.3.4 Бизнесийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийг хамгийн өндөр түвшинд байлгах зарчмыг баримтлах;

3.3.5 Хамтран ажиллах явцад үүссэн болон үүсэж болзошгүй маргааныг зөвшилцлийн журмаар шийдвэрлэж, ур дүнд хүрэхийг чармайх;

3.3.6 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, эдгээртэй адилтгах үйлдлийг хориглосон Монгол улсын хууль тогтоомжийг чанд мөрдөх;

3.3.7 Нэр хүндтэй харилцагч, нийлүүлэгч, хамтрагчтай харилцаж үйл ажиллагаа явуулах;

3.4 Засгийн газрын байгууллагууд:

3.4.1 Татварыг хугацаанд нь бүрэн төлөх;

3.4.2 Засгийн газрын тогтоол, дүрэм журам, шийдвэрийг мөрдөж ажиллах;

3.4.3 Үйл ажиллагаа явуулахад шаардлагатай зөвшөөрлийг холбогдох эрх бүхий байгууллагаас хуулийн дагуу гаргуулан авах;

3.4.4 Засгийн газрын эрх бүхий байгууллагуудтай эрх, ашиг сонирхлоо хамгаалсан харилцааг бий болгоход анхаарах;

3.4.5 Засгийн газрын аливаа байгууллага, шүүх, захиргааны байгууллагад хээл хахууль өгөхийг хүлээн зөвшөөрөх, энэ тухай санал тавихаас татгалзах;

3.4.6 Компани, түүний салбар нь Засгийн газрын аливаа байгууллагатай байгуулсан гэрээ, хэлцэл, хэлэлцээрийн явц, түүнийг дуусгавар болох хүртэлх үйл ажиллагааг холбогдох хэмжээгээр ил тод байлгах;

3.5 Олон нийт, нийгэм ба хүрээлэн буй орчин:

3.5.1 Компани, түүний салбараас олон нийтийн харилцаанд үйл ажиллагаагаа шударга, ил тод, найдвартай, үнэнч, хүндэтгэлтэй явуулах нөхцөлийг бий болгох, зохион байгуулах;

3.5.2 Эдийн засаг тогтвортой үед ажлын байр бий болгох, орон нутгийг хөгжүүлэхэд оролцох;

3.5.3 Хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа Компани, түүний салбарын үйл ажиллагааны үр дагавар, үр өгөөжгүй зарцуулалтыг бууруулах, эрчим хүчийг үр нөлөөтэй ашиглах, хэмнэх, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хүрээлэн буй орчинд ээлтэй үйл ажиллагааг нэвтрүүлэх;

3.5.4 Ажилтнууд болон эрх бүхий албан тушаалтнуудыг орон нутгаас зохион байгуулж буй сайн үйлсийн аян, эрүүл мэнд, боловсролын төсөл хөтөлбөрүүдэд идэвхтэй оролцуулах, эдгээр үйл ажиллагааг зохион байгуулах;

3.5.5 Нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчныг тогтвортой байлгах, сайжруулах үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай хамтарч ажиллахыг чармайх, үйл ажиллагаа хамтран зохион байгуулах;

3.5.6 Компаниас нийгмийн хөгжилтэй холбоотой бий болсон онцгой хэрэгцээг хангах талаар явуулж буй үйл ажиллагааг танилцуулах, нээлттэй өдөрлөг зохион байгуулах;

Дөрөв. Хяналт, хариуцлага

4.1. Компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтан ёс зүйн дүрэм зөрчсөн, зөрчиж болзошгүй аливаа үйлдэл, эс үйлдлийг Комплайнсын ажилтан нэн даруй мэдэгдэж, шүгэл үлээгч байна.

4.2. Ажилтны ёс зүйн дүрэм зөрчсөн мэдээллийг комплайнсын ажилтан хянаад холбогдох саналыг гүйцэтгэх удирдлагад шилжүүлж, шийдвэрлүүлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд ТУЗ-д хүргүүлнэ.

4.3. Комплайнсын ажилтны дүгнэлтийг үндэслэн гаргасан зөрчил, хохирлын хэмжээг харгалзан ажилтанд гүйцэтгэх захирлын тушаалаар Хөдөлмөрийн дотоод журамд заасан сахилгын шийтгэл, эрх бүхий албан тушаалтанд ТУЗ-ийн тогтоолоор шийдвэрлэсэн хариуцлагыг оногдуулна.

4.4. ТУЗ Компанийн эрх бүхий албан тушаалтанд хариуцлага ногдуулах асуудлыг шаардлагатай тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэж болно. .

4.5. Компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтны ёс зүйн дүрэм зөрчиж, зөрчил гаргасан нь гэмт хэргийн шинжтэй бол холбогдох хууль хяналтын байгууллагад шилжүүлэх эрхтэй.

4.6. Ёс зүйн дүрэм зөрчиж, зөрчил гаргаж, шийтгэл хүлээсэн өдрөөс хойш нэг жилийн хугацаанд зөрчилтэйд тооцно.

--o0o--